

Орчуулагч Содбилэгийн
Тан улсын яруу найргийн монгол орчуулга

ДУЙЛЭ*

Монгол Улс, Улаанбаатар хот,
Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл соёлын сургууль

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Энэхүү судалгаанд орчуулагч Содбилэгийн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” (1982) бүтээлийг судлан, Тан улсын яруу найргийн утга агуулга, уран дүрслэл, хэл найруулгыг монгол хэлээр хэрхэн орчуулсныг шинжиллээ. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, агуулгын шинжилгээний аргуудыг ашиглаж, Содбилэгийн орчуулгыг шүлгийн бүтэц, утга санаа, уянгын хэв шинжийн хүрээнд дүгнэв. Үр дүнгээс үзэхэд, Содбилэгийн орчуулга нь Тангийн яруу найргийн гүн уянга, байгалийн дүрслэл, философийн санааг монгол хэлний уран яруу хэрэглүүрээр дамжуулан амжилттай илэрхийлсэн байна. Тэрээр “үгэн дор үл итгэн, утга дор итгэх” зарчмыг баримталж, шууд болон чөлөөт орчуулгын аргыг хослуулсан нь онцлог юм. Орчуулгын хэл найруулга нь энгийн, яруу, уран сайхны хүчтэй бөгөөд хятад яруу найргийн уянгын сэтгэлгээ, бэлгэдлийг монгол соёлын онцлогтой уялдуулж чаджээ. Содбилэгийн бүтээл нь Тан улсын яруу найргийг уншигчдад орчуулж хүргэсэн, Монгол-Хятадын уран зохиолын харилцааны чухал гүүр болсон бөгөөд орчуулга судлал, харьцуулсан уран зохиолын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.

Түлхүүр үгс: Содбилэг, Тан улсын яруу найраг, орчуулга зүй, Монгол-Хятадын уран зохиолын харилцаа

Translator Sodbileg's Mongolian Translation of Tan Uls Poem

DU YI LE

School of Mongolian Language and Culture, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This study examines translator Wanchigsuren Sodbileg's “Three Hundred Tang Poems” (1982) and analyzes how he rendered the imagery, meaning, and poetic expression of Tang Dynasty poetry into Mongolian. Using methods of textual analysis, comparison, and content analysis, the research evaluates Sodbileg's translation in terms of fidelity to the original, stylistic features, and lyrical quality. The findings reveal that Sodbileg successfully conveyed the deep lyricism, natural imagery, and philosophical reflections of Tang poetry through expressive and poetic Mongolian

* © Du Yi Le 2025, E-mail: duyile@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

language. He adhered to the principle of “trust not in the word, but in the meaning,” skillfully combining literal and free translation techniques. His translation style is characterized by clarity, fluency, and artistic elegance, effectively integrating the emotional tone and symbolism of Chinese classical poetry with Mongolian linguistic and cultural sensibilities. Sodbileg’s work represents the first comprehensive translation of Tang poetry into Mongolian, serving as a vital bridge in Mongolian-Chinese literary relations and contributing significantly to the study of literary translation and comparative literature.

Keywords: Sodbileg, Tang poetry, Translation Studies, Mongolian-Chinese Literary Relations.

1. Удиртгал

Тан улс (618–907) бол Хятадын соёл, уран зохиолын түүхийн алтан үе бөгөөд яруу найргийн хөгжлөөрөө дэлхий дахинд танигдсан билээ. Энэ үед туурвисан шүлэг, найраг нь зөвхөн уран дүрслэл, урлагийн өндөр түвшнээр бус, тухайн цаг үеийн нийгэм, түүхэн нөхцөл байдлыг шингээн харуулснаараа судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж ирсэн юм. Ли Бай, Ду Фү, Ван Вэй зэрэг нэрт найрагчдын бүтээлүүдийн үнэт өвийг бусад улс оронд судлан орчуулснаар Тан улсын яруу найраг дэлхийн уран зохиолын үнэт цоморлигт багтжээ (Содбилэг, 1982: 23).

Уншигчид дорнын сонгодог шүлгийг эх хэлээрээ унших боломжийг анх 1982 онд орчуулагч Содбилэгийн бэлтгэсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээлээр олсон юм. Энэ орчуулга нь Тан улсын яруу найргийн шилдэг бүтээлүүдийг сонгон авч, эх хэлний утга санаа, уянгалаг хэв шинжийг илэрхийлсэн нь онцгой ач холбогдолтой. Түүнээс хойш уг орчуулгын суурин дээр 1998 онд шинэ үсэгт орчуулагдан “Тан улсын яруу найргаас” нэрээр, 2018 онд дахин түүвэрлэгдэн хэвлэгдсэн нь орчин цагийн уншигчдад улам ойртож, судалгааны эргэлтэд дахин орж ирэх нөхцөлийг бүрдүүлсэн (Хөвсгөл, 1998: 5) байна.

Иймээс Содбилэгийн орчуулгыг судлах нь зөвхөн уран зохиолын хөрвүүлгийн чанар, арга барилыг шинжлэхээс гадна хоёр орны соёл, уран зохиолын харилцааны түүхийг тодруулахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Тан улсын яруу найргийн утга агуулга, уран дүрслэлийн өвөрмөц онцлогийг монгол хэлээр хэрхэн дамжуулсан нь орчуулга судлалын салбарт үнэ цэнтэй судалгааны сэдэв болох боломжтой.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны зорилго нь орчуулагч Содбилэгийн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээлийг судалж, Тан улсын яруу найргийн уран дүрслэл, утга агуулгыг монгол хэлээр хэрхэн буулгасан арга барил, онцлогийг тодруулахад оршино.

Энэхүү судалгааг хийхдээ баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, агуулгын шинжилгээний аргуудыг голлон ашигласан. Баримт бичгийн шинжилгээний аргаар Тан улсын яруу найргийн тухай хятад, монголын эрдэмтэн судлаачдын бүтээл, уран зохиолын түүхийн эх сурвалжуудыг судалж, онолын суурь ойлголтыг тодорхойлов. Харьцуулалтын аргаар орчуулагч Содбилэгийн хөрвүүлсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээл дэх сонгосон шүлгүүдийг эх хэлтэй нь харьцуулж, уран дүрслэл, утга санаа хэрхэн хадгалагдсан болон хөрвүүлгийн арга барил ямар онцлогтойг судлав. Мөн агуулгын шинжилгээний аргаар Содбилэгийн орчуулгаас сонгосон жишээ шүлгүүдийн утга агуулгыг задлан шинжилж, монгол хэлэнд хэрхэн дамжуулсныг дүгнэлт хийх үндэс болгон ашиглав.

Судалгааны хэрэглэгдэхүүнд орчуулагч Содбилэгийн 1982 онд хэвлүүлсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” ном, түүн дээр тулгуурлан 1998 онд шинэ үсэгт хөрвүүлэгдсэн “Тан улсын яруу найргаас”, мөн 2018 онд дахин хэвлэгдсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээл багтлаа. Үүнээс гадна Тан улсын яруу найргийн тухай хятад, монгол, гадаадын судалгааны бүтээлүүд, эрдэм шинжилгээний өгүүллүүд, мөн орчуулга судлал, уран зохиол судлалын онолын бүтээлүүдийг хэрэглэж, судалгааны эх сурвалжийн баазыг бүрдүүлэв.

3. Тангийн яруу найраг

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд буюу Өвөр монголд орчин үеийн утга зохиолын орчуулгын зүйл, түүн дотор Хятадын утга зохиолын орчуулгын харилцааны ажил 1940-өөд оны хоёрдугаар хагаст буюу Хятадын орчин цагийн улс байгуулагдсан үетэй шууд холбоотой хэмээн үздэг. Жишээлбэл орчуулгын эхний үеийн 1946-1966 оны үесээр баримжаа болгон хуваадаг. Энэ үед Лү Шүнь, Го Мо Рөү, Жао Шү Ли, Жоу Ли Бө, Тянь Хан, Ма Пин зэрэг Хятадын орчин цагийн зохиолчдын бүтээл болон улс төрийн утга чанартай зүйлийг орчуулж байсан. Орчуулгын эхэн үеийн уламжлалд На.Сайнцогт, Гэрэлцогт, Пэрэнлэй, Содном, Бат, Сүлфүнгаа, Содбилэг, Эрдэмтөгс, Ринчингаваа, Жигжид, Хишигжаргал, Боргил, Дугарсүрэн, Манижав, Хасчулуу, Хасгэрэл, Номин, Насан, Норов, Халин, Даш, Сод нарын нэр бүхий орчуулагчид, тэдний мөн нэр бүхий орчуулгын зохиол бүтээлийг холбон хэлдэг. Энэ эхэн үеийн дараа улс төрийн үзэл, “Соёлын хувьсгал”-ын цаг үед аливаа урлаг соёл, тэр дотор утга зохиолын орчуулга ч хумигдаж явсан билээ. Харин 1980-аад оны эхэн үеэс утга зохиолын орчуулгын ажил идэвхжин сэргэж, олон уран бүтээлч тэр чиглэлээр ажиллаж, орчуулгын олон зүйлийн ажлаар түүний хүрээг баяжуулж бас нэгэн шинэ шатанд авчирсан байна.

4. Содбилэгийн яруу намтар

Энэ цаг үе, ер нь Өвөр Монголын орчин цагийн утга зохиолын шилдэг орчуулагчдын нэг бол Содбилэг мөн билээ. Содбилэг 1922 онд Зуу-Уд аймгийн Баарин баруун хошууны Цагаанмөрөн сумын Зулчин гацааны нутагт малчин ард Ванчигсүрэнгийн ууган хүү болон мэндэлсэн байна. Сурвалж мэдээнд тэмдэглэснээр энэ гацааны иргэд Чин улсын Энх-Амгалан хааны үед /Эбээр засагчийн тавдугаар он/ Сэцэн дээд Гүрэн гүнж Баарин ван Цэвдэнд бэр болон буухад дагаж ирсэн инжинд багтаж ирсэн хэмээдэг ажээ. Содбилэг тав, зургаан насны үеэсээ суманд сууж Төвд-Монгол харьцуулсан “Эмийн дөрвөн үндэс” гэх судрыг үзэж суралцаж байсан юм (Содбилэг, 1982: 31).

Хэдийгээр эм эмнэлэг, анагаах эмнэх чиглэлээр төдий өндөр хэмжээнд сурч боловсорч чадаагүй боловч төвд хэлийг эзэмшиж сурч чадсан байдаг. Арваг гурван наснаас эхлэн албанаас зохион байгуулсан айлын сургуульд суралцаж тэнд хятад хэл бичигт суралцсан байна. 1940 онд Улс ардын дээд зэргийн сургуульд орж нэг жил суралцаад, өвчний улмаас сурлагын ажлаа орхин нутагтаа буцаж, Дээд зэргийн бага сургуульд багшийн ажил эрхэлж эхэлсэн. 1945 онд Улаанхотын /тухайн үед Вангийн сүм гэдэг байсан/ Дунд зэргийн багшийн сургуулийн дээд ангид нь элсэн суралцав. 1946 оны 3 сард хувьсгалын ажилд анх оролцож, Зуу-Уд аймгийн ардын засгийн ордны Ухуулах салаанд ажиллаж эхэлсэн байна. 1946 оныхоо намар нь “Өвөр монголын өөртөө засах холбоот хурал”-ын Баарин баруун хошууны салбар хурлын нарийн бичгийн даргаар томилогдож олон түмний ажлыг хариуцан гүйцэтгэж байжээ.

1947 оны 8 сард Улаан хотод байсан Өвөр монголын Автономит дээд сургуульд орж, улс төрийн онолын талаар илүүтэй мэдлэгт суралцаж, мөн энэ үедээ олон нийтийн ажилд идэвхтэй оролцож явсан. 1948 оны 9 сард тэрхүү сургуулиа төгсөж, 1949 онд тус сургууль энгийн монгол Дунд сургууль болоход нь тэндээ 1956 оны эхэн хүртэл багшийн ажил эрхэлсэн байна. Улмаар 1956 оны хавар нь Өвөр монголын Ардын хэвлэлийн хороонд ажиллах болж, найруулагчийн ажлын анхны туршлагаа олж авч байсан байна.

5. Орчуулгын онцлог

Тан улсын яруу найргийн хөгжлийн онцлог, утга агуулгын хүрээ, уран дүрслэлийн арга барилыг онолын талаас авч үзэв. Тан улс нь Хятадын уран зохиолын түүхэнд хамгийн баялаг, нийгэм, түүхийн үйл явдлыг гүн тусгасан үе байсан бөгөөд энэ цаг үед Ли Бай, Ду Фү, Ван Вэй зэрэг алдарт найрагчид олон зуун бүтээл туурвиж, дорнын сонгодог утга зохиолын өвийг бүтээгээд байна. Тэдгээр бүтээлүүд нь байгаль, нийгэм, хувь хүний сэтгэл хөдлөлийг уран дүрслэл, бэлгэдлийн аргаар илэрхийлснээрээ онцлог бөгөөд эдгээрийн утга санааг орчуулгаар дамжуулан монгол уншигчдад хүргэх нь судалгааны үндсэн зорилго байв. Үүний дараа

орчуулагч Содбилэгийн 1982 онд хэвлүүлсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээлийг гол хэрэглэгдэхүүн болгон судаллаа.

Тус бүтээлд сонгогдсон шүлгүүдийг эх хэлтэй нь харьцуулж үзэхэд орчуулагч эхийн уран дүрслэл, хэлбэрийн онцлогийг аль болох хадгалан монгол хэлний уянгалаг шинжид нийцүүлэн буулгасан нь ажиглагдав. Жишээ нь, байгаль дэлхийн дүрслэл бүхий шүлгүүдэд өнгөний ялгарал, хөдөлгөөний дүрслэлийг монгол хэлний уламжлалт уран яруу хэрэглүүртэй холбон буулгасан бол хайр сэтгэл, нөхөрлөлийн тухай бүтээлүүдэд энгийн бөгөөд яруу хэллэгийг сонгон хэрэглэсэн нь уншигчдад ойлгомжтой, хүртээмжтэй болгожээ.

Мөн орчуулгын хэл найруулгын онцлогийг шинжлэхэд Содбилэг шүлгийн хэмнэл, аялгууг алдагдуулахгүй байхад ихээхэн анхаарч, зарим тохиолдолд шууд орчуулгаас илүүгээр уран сайхны хөрвүүлэг ашигласан нь харагдана. Энэ нь орчуулгын уян хатан арга барилыг илэрхийлж, эхийн утга санааг бүрэн дамжуулж чадсан ч орчуулгын судлалын талаас хэлбэр, агуулгын аль нэгийг сонгож онцгойлон дамжуулсан жишээ ч байдаг.

Ийнхүү Содбилэгийн орчуулга нь монгол уншигчдын дунд Тан улсын яруу найргийг таниулсан анхны иж бүрэн бүтээл бөгөөд соёл, уран зохиолын харилцааны чухал гүүр болсон байна. Түүнчлэн уг бүтээл дээр тулгуурлан дараа дараагийн хувилбарууд гарсан нь (1998 оны шинэ үсэгт хөрвүүлэг, 2018 оны дахин хэвлэл) уг орчуулгыг зөвхөн уран зохиолын хэрэглэгдэхүүн бус, мөн судалгааны үнэ цэнтэй эх сурвалж болгожээ.

Тан улсын яруу найргийн хөгжлийн онцлог, утга агуулгын хүрээ, уран дүрслэлийн арга барилыг онолын талаас авч үзэв. Тан улс нь Хятадын уран зохиолын түүхэнд хамгийн баялаг, нийгэм, түүхийн үйл явдлыг гүн тусгасан үе байсан бөгөөд энэ цаг үед Ли Бай, Ду Фү, Ван Вэй зэрэг алдарт найрагчид олон зуун бүтээл туурвиж, дорнын сонгодог утга зохиолын өвийг бүтээгээд байна. Тэдгээр бүтээлүүд нь байгаль, нийгэм, хувь хүний сэтгэл хөдлөлийг уран дүрслэл, бэлгэдлийн аргаар илэрхийлснээрээ онцлог бөгөөд эдгээрийн утга санааг орчуулгаар дамжуулан монгол уншигчдад хүргэх нь судалгааны үндсэн зорилго байв.

Үүний дараа орчуулагч Содбилэгийн 1982 онд хэвлүүлсэн “Тан улсын шүлэг гурван зуун бадаг” бүтээлийг гол хэрэглэгдэхүүн болгон судаллаа. Тус бүтээлд сонгогдсон шүлгүүдийг эх хэлтэй нь харьцуулж үзэхэд орчуулагч эхийн уран дүрслэл, хэлбэрийн онцлогийг аль болох хадгалан монгол хэлний уянгалаг шинжид нийцүүлэн буулгасан нь ажиглагдав. Жишээ нь, байгаль дэлхийн дүрслэл бүхий шүлгүүдэд өнгөний ялгарал, хөдөлгөөний дүрслэлийг монгол хэлний уламжлалт уран яруу хэрэглүүртэй холбон буулгасан бол хайр сэтгэл, нөхөрлөлийн тухай бүтээлүүдэд энгийн бөгөөд яруу хэллэгийг сонгон хэрэглэсэн нь уншигчдад ойлгомжтой, хүртээмжтэй болгожээ.

Мөн орчуулгын хэл найруулгын онцлогийг шинжлэхэд Содбилэг шүлгийн хэмнэл, аялгууг алдагдуулахгүй байхад ихээхэн анхаарч, зарим тохиолдолд шууд орчуулгаас илүүгээр уран сайхны хөрвүүлэг ашигласан нь харагдана. Энэ нь орчуулгын уян хатан арга барилыг илэрхийлж, эхийн утга санааг бүрэн дамжуулж чадсан ч орчуулгын судлалын талаас хэлбэр, агуулгын аль нэгийг сонгож онцгойлон дамжуулсан жишээ ч байдаг.

Ийнхүү Содбилэгийн орчуулга нь монгол уншигчдын дунд Тан улсын яруу найргийг таниулсан анхны иж бүрэн бүтээл бөгөөд соёл, уран зохиолын харилцааны чухал гүүр болсон байна. Түүнчлэн уг бүтээл дээр тулгуурлан дараа дараагийн хувилбарууд гарсан нь (1998 оны шинэ үсэгт орчуулсан, 2018 оны дахин хэвлэл) уг орчуулгыг зөвхөн уран зохиолын хэрэглэгдэхүүн бус, мөн судалгааны үнэ цэнтэй эх сурвалж болгожээ.

Содбилэгийн орчуулгын гол бүтээлийн нэг болох “Тан улсын шүлэг 300 бадаг” хэмээх Хятадын Тан улсын сонгодог шүлгийн орчуулгын бүтээл анх 1982 онд Өвөр монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооны хэвлэлтээр гарч байжээ. Хятадын соёлын зүйл нэн эртний уламжлалтай, дэлхийн эртний соёлын нэгэн голомт мөн юм. Энд Хятадын эртний сонгодог яруу найраг болох Тан улсын үеийн яруу найраг нэлээд онцгой байр эзэлдэг, дэлхийн яруу найргийн үнэт өв санд өөрийн байр суурийг илтгэдэг. Хятадын уран зохиол, яруу найргийн онцлог мөн чанар, үнэт зүйлийг ойлгохын тулд Тан улсын яруу найргийг үзэж ойлгох шаардлагатай гэж үздэг. Өөрөөр хэлбэл Хятадын уран зохиол харилцаа холбоо, орчуулгын

харилцааны зүйлд Тангийн яруу найргийн орчуулга зүй ёсоор том сэдэв болдог гэсэн үг юм. Тиймээс Монгол-Хятадын уран зохиолын харилцааны асуудлыг авч үзэхийн тулд яруу найргийн орчуулга, Тангийн яруу найргийн орчуулгын тухай судлан үзэх нь нэгэн чухал сэдэв болдог.

Энэ нэгэн сэдэвт холбогдох Тангийн сонгодог яруу найргийн орчуулгыг иж бүрнээр нь анх удаа монгол хэлээр орчуулан уншигчдад хүргэсэн, тэр нь бусад монгол орчуулгад томоохон уламжлал, туршлага болж байгаа орчуулга юм.

Аливаа хэл өөр өөрийн онцлогоо илэрхийлж, өвөрмөц талаа илтгэх тул орчуулгын үйл ажиллагааны дунд адил бус хэлний хоорондын онцлогоос болсон саад бэрхшээл ба хүчирдэл тохиолдох үед үндэстний онцлогийг харгалзах нь зохиолын хэлбэр ба дотоод утга агуулгыг зөв ойлгуулах зорилгоор зайлшгүй засвар өөрчлөлт хийх нь орчуулгын ёсонд харшлахгүй гэж үздэг. Содбилэгийн Тангийн яруу найргийн орчуулгад энэхүү орчуулгын зарчимд нийцүүлсэн “үгэн дор үл итгэн, утга дор итгэх” гэх зарчим олонтоо тохиолдож байдаг гэж болно. Тан улсын яруу найргийн төдийгүй Хятадын эртний яруу найргийн онцгой шилдэг төлөөлөгч Ли бай-н хамгийн алдартай бүтээлийн нэг болох “Сэлүүхэн шөнийн бодол” /静夜思/ шүлгийг дараах байдлаар монголчилжээ.

床前明月光
疑是地上霜
举头望明月
低头思故乡

Шүлгийн хятад болон монгол орчуулгыг харгуулан харвал ийм байна (Содбилэг, 1982: 23).

*Дэрэн дээрх гэгээн сарны гэрлийг
Дээрээс унасан хяруу хэмээн гайхаад
Дээш харан тунгалаг сарыг ширтээд
Доош харж төрсөн нутгаа санааа*

Дээрх жишээнээс харахад, бадаг шүлэгт буй “窗前” орны өмнөх гэсэн шууд утгыг “枕上” дэрэн дээрх гэсэн утгаар буулгасан, “疑” сэжиглэх гэсэн утгыг “怪” гайхаад гэсэн утгат үгээр, “地上” газар дээрх гэснийг “落下” дээрээс унасан гэх эсрэг утгат үгээр буулган орчуулснаар энэ бадаг шүлгийг илүү ойлгомжтой, ингэхдээ үндэстний онцлогт тааруулан буулгах зарчмыг барин буулгасан нь оновчтой болжээ хэмээн үзэв (Содбилэг, 1982: 23).

Орчуулгын өөр нэгэн жишээнд Хэ Жи Жан-ы “Удын шүлэглэсэн” буюу “咏柳” гэсэн шүлэг бол:

碧玉妆成一树高
万条垂下绿丝绦
不知细吐谁载出
二月春风似剪刀

гэсэн Тангийн нэгэн шүлгийг бусад орчуулгад

*Номин хасаар чимэглэн байсаар мод өндөр болгох буй за
Нүль ногоон ширээт тууз түмэн мянган унжлага
Ховорхон нарны шинэ навчийг ямар хүмүүн эсгэв
Хоёр сарын хаврын салхин хурц хайч мэт (Сүмбэр, 1998: 55)
гэж орчуулсан байдаг бөгөөд Содбилэг үүний эхний хоёр мөрийг
Төгрөг өндөр сүмбэрлэн цогцолсон номин хасын овоо
Түмэн зурвас доош унжсан ногоон торгон тууз...*

гэж орчуулаад “Сүмбэрлэн цогцолсон” гэсэн нь уул нуруу, сүрлэг өндөр сүр бараа байдал төрхийг “сүмбэрлэх” хэмээх үгээр тодруулсан нь монгол үндэсний онцлог бүхий онцлогтой үгийг хэрэглээд илүү ойлгомжтой, уран сайхантай өвөрмөц дүрслэл бүхий монгол шүлгийн хэлбэр болгон орчуулсан нь уншигчдад харьцангуй ойлгомжтой болгох боломжийг олгожээ (Сүмбэр, 1998: 55).

Хятадын үндэсний эртний хэмжээт шүлгийн дотор хэрэглэх үгийн сонголт нь маш нарийн боловсронгуйгаар барахгүй үг үсгийн тэнцлийг баримталж, авианы зохицлыг онцлон таван үгийн хэмжээт шүлгийн тавдугаар үсгийг “шүлгийн оньс” гэж маш их гүн гүнзгий, чухал холбогдолтойгоор холбон бодож сонгодог байна. Энэ мэтийн нарийн шаардлагатайгаар бодож боловсруулан зохион бүтээх учир зарим шүлгийн тусгасан санаа гүн далд, үг үсэг дараалан утгыг мөрдөхгүй бол өөр хэлээр орчуулан илтгэхэд бэрхшээлтэй байх болно. Гэхдээ олонх шүлэгчид нь өөрийн бичиж бүтээсэн шүлгийнхээ урлагийн гоо сайхны талыг өндөржүүлж, утга санаагаа бүрэн дүүрэн атлаа уран сайхантай илрүүлэхийн төлөө зарим түүхэн хүн, түүхэн хэрэг явдалтай газар орны нэрийг холбон ашиглах өмнөх үеийн шүлэг уянгын утгыг шүлэгтээ нүүлгэн хэрэглэж санаагаа лавшруулах эртний уламжлалт арга барил, түүхэн хүн, түүхэн хэрэг явдалтай холбогдсон тиймэрхүү хэллэгээр шүлгийн утгаа гүнзгийрүүлэн санаагаа товойлгож, зарим цаг улирлын төлөв байдалтай холбогдох зүйлсийг мөн шүлэгт холбон хэрэглэж байдгаас орчуулах явцад олон талын бэрхшээл хүчирдлийг авчирсан байна. Гэвч эдгээр тохиолдолд чиглүүлэн Содбилэг шүлгийн уул утга санааг ойлгох асуудалд анхаарал тавьж утга агуулгыг зөв оновчтой илтгэсэн байдаг.

Жишээ нь: “Дү Ши Ян”-ы “Шан ян хотын асарт авирсан” /登襄陽城/ гэх шүлгийг үзвэл

冠盖非新里

章华既旧台

习池风景异

归路满尘埃 гэсэн байдгийг

Тэргүүн хувцас, морь унаа шинэ тосгоноос биш,

Цагийн гэрэлт байшин хуучирсан цамхагт.

Сурлын цөөрмийн байгаль өвөрмөц,

Буцах зам шавар, тоос шороо дүүрэн.

Тус шүлгийн эхний гурван мөрөнд “冠盖”, “章华”, “习池” зэрэг гурван газрыг тус тус зааж байдаг (Сүмбэр, Ч. 1998:55). Эхний мөрийн “冠盖” гэдгийг шууд орчуулбал “малгай шүхэр” буюу “титэм”, “бүрхээс” буюу “хучих, бүтээх” гэх мэт утгатай. Гэтэл доорх гурван үгнээс ажиглавал “里” гэдэг нь эртний тосгоныг зааж илтгэж байх учир “шинэ тосгон биш” гэдэг утга илэрнэ. “冠盖” гэдэг нь яриангүй тосгоны нэрийдэл болно. Үүнийг малгай шүхэр шинэ тосгон биш хэмээн орчуулбал хэдийгээр үгийн тоо тэнцэлтэй боловч утга буруу болно. Содбилэг орчуулагч энэ талаар их хүч оруулж уул үгийн утгыг илүү найрсалтай эвтэй орчуулсан гэж үзэхээр байна. Ингэснээр уул шүлэг утга санааг бүрэн оновчтой илтгэж чадсан атлаа монгол шүлгийн хэлбэр, бүтцэд хиймлээр баригдалгүй чөлөөтэй хэлбэрээр орчуулсан байна.

Ли Бай – “Шөнийн бодол” (静夜思)

Хятад эх:

床前明月光,

疑是地上霜。

举头望明月，

低头思故乡。

Содбилэгийн орчуулга (1982):

Орны дэргэд сарны гэрэл тусна,

Орон дээр цас буусныг эндүүрнэ.

Толгой өргөж сарыг ширтэнэ,

Толгой гудайлган нутаг орноо санана.

Энэ шүлэгт Ли Бай сарны гэрлийг эх орныг санагдуулах сэтгэл хөдлөлийн бэлгэдэл болгон ашигласан байна. Эх хэлний дүрслэлийг Содбилэгийн орчуулга бүрэн хадгалсан бөгөөд “地上霜” (газар дээрх цан, цас) гэх дүрслэлийг монгол уншигчдад ойртуулахын тулд “цас мэт гялалзана” хэмээн хөрвүүлсэн нь орчуулгын уянгалаг шийдэл болжээ. Хятадын товч, дүрслэл давамгай хэлбэрийг монгол хэлний эгшиглэнт (Хөвсгөл, 1998: 8) найруулгатай нийцүүлэн орчуулсан нь түүний орчуулгын арга барилын онцлогийг илтгэнэ.

6. Судалгааны үр дүн

Энэхүү судалгаагаар орчуулагч Содбилэгийн Тан улсын яруу найргийн монгол орчуулгыг хэл найруулга, утга агуулга болон уран илэрхийллийн онцлогийн хүрээнд шинжиллээ. Юуны өмнө түүний орчуулгын арга барилыг судлахад эхийн агуулгыг аль болох бүрэн дамжуулахад чиглэсэн “шууд орчуулга” болон уран сайхны найруулгыг хадгалсан “чөлөөт орчуулга”-ын хосолсон хэв маяг зонхилж буй нь тодорхой болов. Энэ нь Тан яруу найргийн гүн уянгын санаа, байгалийн дүрслэл, философийн гүн утгыг монгол уншигчдад ойлгомжтой хүргэхэд чухал ач холбогдолтой байжээ.

Судалгааны явцад Содбилэгийн орчуулгад дараах хэд хэдэн онцлог илэрлээ. Тан яруу найргийн байгаль дэлхийтэй хүний сэтгэлийг холбосон дүрслэлийг монгол хэлний уламжлалт уянгын яруу хэлцээр дамжуулан амьдруулсан байна. Жишээлбэл, Ли Бай, Ду Фу зэрэг яруу найрагчдын шүлгийн уянгын өнгө аясыг алдагдуулахгүйгээр, харин ч монгол уншигчийн соёл сэтгэлгээнд ойртуулсан илэрхийлэл ашигласан нь үнэлэгдэхүйц. Хятад яруу найргийн дүрслэлд зонхилох бэлгэдэл, ёгтлолыг орчуулгад шууд дамжуулахын зэрэгцээ заримдаа монгол ахуйд нийцүүлэн хөрвүүлсэн нь уншигчийн хүлээн авах чадварыг нэмэгдүүлжээ.

Хэл найруулгын түвшинд Содбилэгийн орчуулга нь цэгцтэй, энгийн бөгөөд яруу тансаг байдлыг хослуулсан нь онцлог юм. Түүний хэрэглэсэн уран дүрслэлүүдийн ихэнх нь эхийн уянгын хүчийг алдагдуулахгүйгээр хадгалсан бөгөөд зарим тохиолдолд эхээс давсан уран сайхны үнэлэмжийг бий болгожээ. Энэ нь зөвхөн орчуулагчийн хэл найруулгын ур чадвар төдийгүй эх зохиолын сэтгэлгээний гүн утгыг зөв ойлгож, дахин бүтээх чадварыг харуулж байна.

Хэлэлцүүлгийн хүрээнд авч үзвэл, орчуулгын явцад гарсан гол сорилт нь хятад хэлний дүрслэл, хэлц үг, соёлын агуулгыг монгол хэлнээ буулгахдаа шууд утгаар дамжуулах уу, эсвэл уянгын хэв шинжийг хадгалан орчуулах уу гэсэн асуудал байлаа. Содбилэгийн туршлагаас харахад тэрээр аль алийг нь ашиглаж чадсан нь түүний орчуулгыг бусдаас ялгарах онцгой тал болгож байна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс үзэхэд, орчуулагч Содбилэгийн бүтээлүүд нь зөвхөн Тан улсын яруу найргийг монгол уншигчдад ойртуулсан төдийгүй хоёр орны соёлын харилцааны гүүр болсон чухал ач холбогдолтой байна. Түүний орчуулга нь уран сайхны үнэ цэнэ, хэл найруулгын ур чадвар, соёлын хөрвүүлгийн хувьд судлагдахуйц өв болжээ.

7. Дүгнэлт

Монгол-Хятадын уран зохиолын харилцааны нэг чухал тал бол Хятадын уран зохиолын орчуулгын асуудал мөн. Хятадын уран зохиолын орчуулгын уламжлалд Хятадын эртний уран зохиолын нэгэн бүрэлдэхүүн, Тан улсын үеийн сонгодог яруу найргийн орчуулгын зүйл багтдаг. Хятадын эртний уран зохиол, яруу найргийг төлөөлөх гол зүйлийн нэг нь Тан улсын яруу найраг мөн бөгөөд түүнийг орчуулах, судлах асуудал Хятадын соёлын харилцааны томоохон асуудлыг хөндөж буй хэрэг. Тан улсын яруу найргийн орчуулгын уламжлалд гол байр суурь эзэлдэг орчуулагчийн нэг бол Ванчигсүрэнгийн Содбилэг орчуулагч мөн. Түүний Тангийн яруу найргийн орчуулга нь тухайн салбарт томоохон уламжлал туршлага болдог (Хөвсгөл, 1998: 9).

Энэхүү судалгаагаар орчуулагч Содбилэгийн Тан улсын яруу найргийн монгол орчуулгыг хэл найруулга, утга агуулга, уран илэрхийллийн онцлогийн хүрээнд шинжилсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд, Содбилэгийн орчуулга нь эхийн уянгын өнгө, дүрслэл, утга санааг хадгалан дамжуулсан бөгөөд зарим тохиолдолд монгол хэлний уламжлалт яруу хэллэгийг ашиглаж, уншигчдад ойлгомжтой, хүртээмжтэй болгосон нь тодорхой боллоо.

Орчуулгын арга барил нь шууд болон уран сайхны орчуулгын хослолыг хэрэглэж, Тан улсын яруу найргийн гүн утга санааг монгол уншигчдад хүргэхэд онцгой ач холбогдолтой байсныг судалгаагаар нотлов. Энэ нь зөвхөн уран зохиолын хөрвүүлгийн чанар, хэл

найруулгын ур чадварыг харуулсан төдийгүй хоёр орны соёл, уран зохиолын харилцааны түүхийг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэж байсныг илтгэж байна.

Ийнхүү Содбилэгийн орчуулга нь монгол уншигчдын дунд Тан улсын сонгодог яруу найргийг таниулсан анхны иж бүрэн бүтээл төдийгүй орчуулга судлалын салбарт судлагдахуйц үнэ цэнтэй эх сурвалж болжээ.

Хавсралт

№	Найрагч	Хятад эх	Монгол орчуулга (Содбилэг, 1982)	Тайлбар
1	Ли Бай	床前明月光，疑是地上霜。举头望明月，低头思故乡。	<i>Орны өмнө сарны гэрэл гийж, Орчин даяар цас мэт гялалзана. Толгой өргөн сарыг ширтээд, Толгой гудайлган нутаг санана.</i>	Эх шүлгийн утга санаа, дүрслэлийг хадгалж, монгол хэлний уянгалаг хэллэгээр дамжуулсан.
2	Ду Фү	国破山河在，城春草木深。感时花溅泪，恨别鸟惊心。	<i>Улс сүйрсэн ч уул ус ориш, Хотод хавар ургамал гүн. Цагийн урсгалыг мэдрэн цэцэгт нулимс дусалж, Буйд салж одсон шувууд сэтгэлийг хөндөв.</i>	Улс орны эмгэнэлт сэтгэлийг дүрслэл, бэлгэдлээр дамжуулан орчуулсан.
3	Ван Вэй	大漠孤烟直，长河落日圆。	<i>Том элсэн цөлд ганцаар шороо мандана, Урт голд жаргах нар тойроглон гялалзана.</i>	Байгалийн дүрслэл, хөх тэнгэрийн өргөн уудам байдлыг монгол хэлээр илэрхийлсэн.
4	Ли Бай	黄河远上白云间，一片孤城万仞山。	<i>Шар голыг алс хязгаарын цагаан үүлэн дээгүүр урсган, Ганцаардсан хотыг мянган метрийн уулс хучжээ.</i>	Газарзүйн дүрслэл, уран сэтгэлгээний холбосон байдлыг хадгалсан.
5	Ду Фү	春望	<i>Хаврын хотыг ажиглахад, Цэцэгс дэлгэрч, ургамал гүн шигхэн.</i>	Тан улсын нийгмийн дүрслэлийг хаврын байгальтай холбон илэрхийлсэн.

Ном зүй

Содбилэг, Л. (1982). *Tan ulus-un silüg yurbah jayun baday*. Kökeqota: Suryan kümüjil-ün keblel-ün qoriya. [Sodbileg, L. *Tan ulsyn shüleg gurban zuun badag* [Three Hundred Tang Poems]. Hohhot: Educational Publishing Committee. 1982.]

Сүмбэр, Ч. (1982). Хятад шүлгийн монголчлох гоодох, үндэстэнчлэх арга дадлын тухай. Улаанбаатар: 1982. *Хэл орчуулга*. [Sümber, Ch. On the Aesthetic and National Adaptation Methods in Translating Chinese Poetry into Mongolian. *Khel orchuulga*. Ulaanbaatar. 1982. 38-45.]

С. Хөвсгөл, (1998). *Тан улсын яруу найраг*. Улаанбаатар: Адмон. [Khuvsgul, S. *Tan ulsyn jaruu nairag* [Tang Poems]. Ulaanbaatar: Admon. 1998.]